



МИНИЙ ХАРСАН ЭНЭТХЭГ ОРОН

Доктор О.Нямдаваа

Өнөөдрийн Энэтхэг орон дэлхийд нэр хүнд, нөлөө бүхий цөмийн зэвсэгтэй, өөрийн хиймэл дагуул хөөргөсөн, үндэсний пуужинтай том гүрэн болж өсч байна. Түүний зэрэгцээ мэдээллийн технологиор дэлхийн хэт их гүрэн болох замдаа тууштай орж, 2008 онд жилд 50 тэрбум ам.долларын программ хангамж галаадад экспортлох гаргах зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Энэтхэгийн үйлчилгээний салбарын экспортын хэмжээ 100 тэрбум ам.долларт хүрч байгаагаас софтверийн экспорт нь 34 тэрбумд өнөөдөр хүрээд байна. Өөрөөр хэлбэл тавьсан зорилгодоо хүрэх бүрэн боломжтой байна гэсэн үг юм.

Үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний хэмжээгээр Энэтхэг /худалдан авах чадвараар/ дэлхийд АНУ, Япон, Хятад, Германы дараа 5 дугаарт орж байна. Энэ нь тоон үзүүлэлтээр /худалдан авах чадвараар/ 3.3 триллион ам долларт хүрч байна. Гадаад валютын нөөцийн хэмжээ 140 тэрбум гаруй ам. долларт хүрээд байна.

Энэтхэгчүүд нэг тэрбум гаруй хүн амаа хүнсний болон үйлдвэрийн бүтээгдэхүүнээр бүрэн хангаад зогсохгүй, илүүг нь гадаадад гаргаж Ази тивийн хүчирхэг том гүрнүүдийн нэг болон өндийлөө.

21 дүгээр зуун Азийн зуун болно гэж эрдэмтэд төсөөлөн ярьж байгаатай Энэтхэгчүүд санал нэг байж тэр зууныг бүтээх, түүнд гар бие оролцон байгуулахад өөрийн орныг бүх талаар өргөн хүрээтэй бэлтгэж, түүнд зонхилох байр суур эзлэхээр чармайн ажиллаж байна. Бүс нутагтаа болон дэлхий дахинд өөрийн үүрэг, хариуцлагыг мэдрэн, энх тайван, тогтвортой байдлыг Ази болон дэлхий дахинд бий болгоход тодорхой үүрэг гүйцэтгэсэн, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн болохоор Энэтхэг идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Ийнхүү эрч хүчээ энэхүү зууны эхэн үеэс аван, босч өндийгөөд, шуудхан алхаж эхэлсэн "Азийн цагаан заан"-аар төсөөлөн боддог Энэтхэг орныг гадаадын зарим орон бидний адилаар төсөөлөн хүлээн авдаг байдал ажиглагддаг.

Зарим гадаадын хүн Энэтхэгт очоод тэнд ядуу амьдрал байгааг шүүмжлэн ярьдаг. Түүний хариуд энэтхэгийн нэгэн профессороос "Энэтхэгийн зөвхөн хөрөнгөтэй, чинээлэг хүмүүсийн тоо л АНУ-ын хүн амтай тэнцэж байна" гэж хариу барьсныг би мартдаггүй юм. Тэрбээр цааш нь хэлэхдээ "Тэрбум гаруй хүнийг бүгдийг бичиг үсэгтэй, сургууль соёлтой болгохоор мөнгө зарах шаардлагагүй. Бүгдээрээ дээд боловсролтой, нарийн мэргэжилтэй болох аваас үйлчилгээний өргөн салбарт хэн

маань ажиллах юм бэ. Манай Энэтхэг оронд 200 гаруй сая хүн нарийн мэргэжилтэй байж дэлхийн хэмжээнд ажиллах аваас улс орныг урагш нь чирээд явна. Ийм л бүх тэргийг бид бэлтгэх хэрэгтэй” гэж байсан. Ийм бодол санаатай хүмүүс Энэтхэгт олон байдаг.

Саяхан Энэтхэгийн Делид эргэж очлоо. Дели хот метротой болж газар дээг үүр байдаг ачааллаасаа бүрэн гарч эхэлжээ. Тэр метро нь орчим үеийн шинэ техник технологийн ололт амжилтыг агуулсан байв. Тэнд зорчиж байгаа хүмүүсийн нүдэнд баясал, гэрэл гэгээ тусч, итгэл үнэмшил, зорилго эрмэлзэлтэй урагшаа алхаж байгааг харахдаа таатай байлаа.

Хэдхэн жилийн өмнө бусад муж, хотуудтай холбогдсон Дели руу ордог, гарлаг зам ачаалал ихтэй байсныг өөрчлөөд, давхар гүүрэн зам тавьж түгжирлээс гарчээ. Дели-Жайпурын хооронд нэг урсгалтай хурдны зам тавьсан байв. 300 гаруй километр газарт 3 цаг давхиад хүрэх боломж бий болжээ. Дэд бүтэц бол бүх хөгжлийн анхны түлхүүр гэсэн ойлголтоор тэд ажиллаж байна.

Энэтхэгт гадаадын хөрөнгө оруулалт орж байна. Гэхдээ хаана гадаадын хөрөнгө оруулж болох, хаана хамтарсан үйлдвэр байгуулж болохыг заасан хууль дүрэмтэй. Өөрөөр хэлбэл үйлчилгээний болон өөрсдөө хийж, үйлдвэрлэж чадах салбартаа зөвхөн үндэсний компаниа хооронд нь уралдуулж, үндэснийхээ эрх ашиг хамгаалсан бодлого явуулж байна. Ашигт малтмал болон газар дор байгаа “үүцээ” тэр болгон задлах нь хойч үед харшилна гэсэн бодлогыг Энэтхэг баримталж, цөөн хэдийгээ нээж байна. Монголд элэгтэй Энэтхэгийн зарим мэргэжилтэн, улс төрчдөөс “өөрийн үүцийг эмх замбараагүй нээж задлах нь ирээдүйн иргэдэд муу нөлөөтэй байж, үндэсний ашигт малтмалыг шавхан дуусгаж, байгаль орчныг сүйтгэн сөнөөх аюулд хүргэж болзошгүй юм. Ашигт малтмал бол дахин ургадаггүй зүйл” гэж олон жилийн өмнөөс зөвлөж байсан нь санаанаас гардаггүй юм.

Ийнхүү өнөөдрийн Энэтхэг улсын дуу хоолой дэлхийн тавцанд их жин татаж байгаа нь бусад улс орон тэдний үг, санал санаачлага, үйл ажиллагааг их анхааралтайгаар сонсдог болж, энэтхэгчүүдийн бүтээж үйлдвэрлэж байгаа зүйл, сөрөнхий чадавхийг үнэлж байгаатай холбоотой бололтой.